

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ (2025 он)

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202501/01. Монголиан Эйрвэйс ХХК, нисдэг тэрэг ашиглагч нарт. /Safety recommendation 202501/01. Mongolian Airways LLC and /.

“AS350 B3 маягийн, 7096 серийн дугаартай нисдэг тэрэгний ARRIEL D2 маягийн, SN51065 серийн дугаартай хөдөлгүүрийг дахин ашиглах эсхүл шалгалт хийлгэх шаардлагатай гэж үзвэл үйлдвэрлэгч-д илгээж баталгаажуулах.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202504/02. ИНЕГ-т, МИАТ ХК-д. /Safety recommendation 202504/02. MCAA, MIAT Mongolian Airlines /.

“Агаарын хөлгийн бүхээгийн битүүмжлэл алдагдсан тохиолдол удаа дараалан гарч байсан бөгөөд нисгэх баг нислэгийн ашиглалтын зааврын дагуу ажиллаж чадахгүй байгаатай холбогдуулан тус компанийн бүх нисгэх бүрэлдэхүүнд бүхээгийн даралтын системийн талаар онолын сургалт зохион байгуулах, бүхээгийн дадлагажуурын хөтөлбөрт оруулж сургалтанд хамруулах”.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202504/03. ИНЕГ-т. /Safety recommendation 202504/03. MCAA/.

МИАТ ХК-ийн нислэгийн ажлын зохион байгуулалт, нисгэх багийн бэлтгэл, нислэгийн аюулгүй байдлын шаардлага хангахгүй байгаа тул дараах арга хэмжээг авах шаардлагатай байна. **Үүнд:** Агаарын тээврийн ATPL үнэмлэх шаардагдах агаарын хөлгийн нисгэгчдийг сонгох, бэлтгэх ажиллагаа болон агаарын тээврийн нисгэгчийн онол/theoretical/, ур чадвар/skill/, туршлага/practical/-ын шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаж баталгаажуулах.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202504/04. ИНЕГ-т. /Safety recommendation 202504/04. MCAA/.

Агаарын хөлгийн зөрчил гарсан тохиолдолд нислэгийн үеийн бүх төрлийн бичлэгүүдийг авч хадгалах, хамгаалах, шаардлагатай тохиолдолд агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах эрх бүхий байгуулагад өгөх тогтолцоог бүрдүүлэх.